



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2015 оны 06 сарын 24 өдөр

Дугаар 282

Улаанбаатар хот

“Пийс оф лайф” ХХК-ийн даатгалын зуучлагчийн<sup>1</sup>  
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2.4, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 39 дүгээр зүйлийн 39.1.4, 39.1.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Пийс оф лайф” ХХК-ийн даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. “Пийс оф лайф” ХХК-ийн даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохтой холбогдуулан тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хураан авч, Хорооны бүртгэлд холбогдох өөрчлөлт хийлгэхийг Хяналт шалгалтын газар/Б.Оюунцацрал/-т үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд болон харьяалагдах татварын алба, Улсын бүртгэлийн ерөнхий газарт 10 хоногийн дотор мэдээлж ажиллахыг Ажлын алба /Б.Батсэлэнгэ/-нд даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

000874